

ДУЛААН ДАМЖУУЛАХ, ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНИЙ “ХОЛБОЛТЫН ЖУРАМ”

2.5. Иргэн, хуулийн этгээд нь дулаан дамжуулах, түгээх сүлжээнд объектоо холбуулах хүсэлтээ "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2 дугаар зүйлийн 2.1-т заасан баримт, бичгийг бүрдүүлж техникийн нөхцөл олгогчид гаргана. /Энэ хэсгийг ЭХЗХ-ны 2020 оны 622 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан./

2.5.1. албан бичиг, өргөдөл;

2.5.2. иргэний үнэмлэхийн хуулбар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (эх хувь, эсвэл хуулбарыг гэрчлүүлсэн байх);

2.5.3. техникийн нөхцөл олгогчоос өгсөн тодруулах хуудасны бүрдэл; /Нэгдүгээр хавсралт/

2.5.4. газрын гэрчилгээ (өмчлөх, ашиглах, эзэмших), (эх хувь, эсвэл хуулбарыг гэрчлүүлсэн байх);

2.5.5. газрын кадастрын зураг (эх хувь, эсвэл хуулбарыг гэрчлүүлсэн байх);

2.5.6. дулааны ачаалал, хэрэглээг тооцсон тоо хэмжээ; /Энэ заалтуудыг ЭХЗХ-ны 2020 оны 622 дугаар тогтоолоор хүчингүй болгсон./

2.6. Иргэн, хуулийн этгээд нь энэхүү журмын 2.5-т заасан баримт, бичгээс гадна хүсэлтийн онцлогоос хамаарч техникийн нөхцөл олгогчоос шаардсан холбогдох бусад материалуудыг бүрдүүлнэ./Энэ хэсгийг ЭХЗХ-ны 2020 оны 622 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан./

2.6.1. хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдуулан барилга орон сууц барих тохиолдолд Архитектур төлөвлөлтийн даалгавар, батлагдсан “Ерөнхий төлөвлөгөө” (эх хувь эсвэл хуулбарыг гэрчлүүлсэн байх);

2.6.2. олгогдсон техникийн нөхцөлд өөрчлөлт оруулахад өмнөх техникийн нөхцөлийн хуулбар хувь;

2.6.3. техникийн нөхцөлийн нэр шилжүүлэхэд өмнө олгогдсон техникийн нөхцөлийн эх хувь, газрын гэрчилгээ, харьяа хорооны тодорхойлолт;

2.6.4. дулааны сүлжээг зөөж байршлыг өөрчлөхөд түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс зураг төсөлд тодруулга тодорхойлолт, харьяа орон нутгийн ерөнхий төлөвлөгөө эрхэлсэн газрын албан хүсэлт;

2.6.5. хэрэв бусдын өмчлөлийн дулааны шугам, тоног төхөөрөмжид барилга, объектыг холбох бол тухайн өмчлөгчтэй зөвшилцсөн /гэрээ, тодорхойлолт, албан бичиг/ бичиг; /Энэ заалтуудыг ЭХЗХ-ны 2020 оны 622 дугаар тогтоолоор хүчингүй болгсон./